



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 26 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлтийг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Түвшин Оргил” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хавсралтад заасны дагуу 80,000,000.00 / наян сая/ төгрөгөөр хорогдуулсан өөрчлөлтийг бүртгэсүгэй.


2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Түвшин Оргил” ХХК /Ж.Түвшин/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 6 дугаар сарын 26-ны
өдрийн 174-р тогтоолын хавсралт

УХА0410 5043230

“ТҮВШИН ОРГИЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Эхний үлдэгдэл | | | Өөрчлөлт | | | Эцсийн үлдэгдэл | | |
|---|-------------------------------|-------------------------|---|----------------------------------|-------------------------|-----------|----------------------|-------------------------|---|----------------------------------|
| | | Хувьцааны тоо ширхэг | Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 5,000 төгрөгөөр/ | Дүрмийн санд эзлэх хувь | Хувьцааны тоо ширхэг | Нэмэгдсэн | Хорогдсон | Хувьцааны тоо ширхэг | Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 5,000 төгрөгөөр/ | Дүрмийн санд эзлэх хувь |
| 1 | Б.Баяр /ГЕ85080400/ | 20,000 | 100,000,000.00 | 100% | (16,000) | - | 80,000,000.00 | 4,000 | 20,000,000.00 | 100% |
| | Нийт | 20,000 | 100,000,000.00 | 100% | (16,000) | | 80,000,000.00 | 4,000 | 20,000,000.00 | 100% |